

Төв аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2014 оны 6 дугаар сарын байдлаар)

I. Нийгмийн үзүүлэлт




I.1 Бүртгэлтэй ажилгүй иргэн.

2014 оны 6-р сард Хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 967 болж, 2013 оны мөн үеэс 291 хүнээр, өмнөх сарынхаас 115 хүнээр тус тус өсөв.

Ажилгүйчүүдийн 51,71 хувь буюу 500 нь эмэгтэйчүүд юм. 2014 оны эхнээс 953 ажлын байр захиалгад бүртгэгдсэнээс 313 ажлын байранд иргэд зуучлагдан ажилд оров. Ажилд зуучлагдсан иргэдийн 38,66 хувь буюу 121 нь эмэгтэйчүүд байна.

Зураг I.1

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон иргэд, жил бүрийн 6 дугаар сарын эцсийн байдлаар




Тайлант сард бүртгүүлсэн 508 ажилгүй иргэний 27,2 хувь нь цалин орлого хүрэлцэхгүй байгаа; 19,1 хувь нь өрхийн болон хувийн аж ахуй эрсдэлд орж орлогогүй болсон; 18,5 хувь нь мэдлэг чадвараа ашиглан орлогоо нэмэгдүүлэх; 14,8 хувь нь сургууль төгссөн, чөлөө авсан; 4,3 хувь нь өөр газраас шилжин

ирсэн; 2,0 хувь нь орон тооны цомхтголд орсон; 1,8 хувь нь гүйцэтгэж буй ажил албан тушаалдаа тэнцэхгүй болсон; 1,8 хувь нь байгууллага татан буугдсан; 1,6 хувь нь одоо эрхэлж буй ажлаа солих; 1,2 хувь нь гадаадаас эргэж ирсэн, 0,8 хувь нь цэргээс халагдсан; 7,1 хувь нь бусад шалтгаанаар тус тус бүртгүүлжээ.

Ажилгүйчүүдийг боловсролын төвшинээр хуваавал 4,96% нь дээд; 17,48% нь тусгай дунд; 46,54% нь мэргэжлийн анхан шатны; 10,96% нь бүрэн дунд; 5,97% нь бүрэн бус дунд боловсролтой; 14,89% нь бага буюу боловсролгүй иргэн байна.

Зураг I.2

Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, 2014 оны 6 дугаар сарын эцсийн байдлаар



Эх үүсвэр: Хөдөлмөрийн хэлтсийн сар бүрийн мэдээ

*- Ажил хайгч гэж ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн иргэнийг ойлгоно.



I.2 Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын байгууллагын мэдээгээр 2014 оны эхний 6 сард НДШ-ийн орлого 7242.8 сая ₮ болж төлөвлөгөө 88.67 хувь болж, төлөвлөгөөг Борнуур сум 106.97 хувиар биелүүлж, бусад сум 7.29-16.87 хувиар тасалдууллаа. Сайн дурын НДШ-ийн орлого 355.2 сая ₮ болж төлөвлөгөөг Баянчандмань сум 100.07 хувь Борнуур сум 100.82 хувиар биелүүлж, бусад сум 1.03-7.40 хувиар тасалдууллаа.

Тэтгэвэр, тэтгэмжинд 15261.7 сая ₮ зарцуулж, олголт 100.0 хувь боллоо. Олгосон тэтгэвэр, тэтгэмжийн 79.0 хувийг өндөр настны, 10.0 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 4.0 хувийг тэжээгчээ алдсаны, 5.0 хувийг цэргийн тэтгэвэрт тус бүр зарцуулжээ.

Нийгмийн даатгалын сангаас олгосон дундаж тэтгэвэр 225000 ₮ боллоо.

Нийгмийн даатгалын нийт зарлагын 42.9% хувийг орлогоороо бүрдүүлснээс тэтгэврийн даатгалын сангийн 32.6%; тэтгэмжийн даатгалын сангийн 103.02%; эрүүл мэндийн даатгалын сангийн 87.5%; үйлдвэрлэлийн осол мэргэжилээс шалтгаалах өвчний даатгалын сангийн 198.01%; ажилгүйдлийн даатгалын сангийн 163.7%-ийг тус бүр бүрдүүлжээ.

Нийгмийн халамж

Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн мэдээгээр 2014 оны эхний 6 сард нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламжийг 105647 хүнд олгож, 5.5 тэрбум ₮-ийг зарцуулж 2013 оны мөн үеэс хүний тоо 2.1 дахин 71364 хүнээр, зарцуулсан мөнгөний хэмжээ 36.6 хувь 1.48 тэрбум ₮-өөр өслөө.

Нийгмийн халамжийн дундаж тэтгэвэр 104560 болжээ. Олгосон тэтгэвэр, тэтгэмж,

тусламжийн 31.8 хувийг хүүхдийн хөгжил сангийн мөнгө; 24.5 хувийг халамжийн тэтгэвэр; 9.4 хувийг жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж; 5.8 хувийг төрөл бүрийн нөхцөлт мөнгөн тусламж; 2.2 хувийг нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж; 3.7 хувийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн хамгааллын хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт, тусламж; 0.9 хувийг алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламжид тус бүр зарцуулжээ.




1.3 Эрүүл мэнд

2014 оны эхний 6 сард 8510 өвчтөн эмнэлэгт хэвтэн эмчлэгдэн гарсан нь нэг өвчтөнд дунджаар 7.8 ор хоног ногдлоо.

Эрүүл мэндийн байгууллагын мэдээгээр 2014 оны эхний 6 сард 675 хүүхэд мэндэлсэн нь 2013 оны мөн үеэс 90 хүүхдээр өслөө.

Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн 6 дугаар сарын байдлаар



Аймгийн хэмжээнд 2014 оны эхний 6 н сард нялхсын эндэгдэл 5 хүүхэд гарч өмнөх оны мөн үетэй ижил байна.

5 хүртлэх насандаа эдсэн хүүхэд гараагүй ба өмнөх оны мөн үед харьцуулвал 50 хувиар буюу 1 хүүхдээр буурсан байна.

Зураг 1.4


Эндсэн хүүхдийн тоо, жил бүрийн 6 дүгээр сарын байдлаар



2014 оны эхний 6 сард нийт гарсан халдварт өвчнөөр 258 хүн өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 18.8 хувь буюу 93 хүнээр буурлаа. 2013 оны мөн үеэс трихомениаз 2.8 дахин, заг хүйтэн 1.4 дахин, тус бүр өсчээ. 10000 хүнд ногдох өвчлөл аймгийн дундаж 29 байгаа бол: Зуунмод 79, Сүмбэр 70, Мөнгөнморьт 50, Сэргэлэн 32, Дэлгэрхаан 32, ногдлоо.

Зураг 1.5

10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо, жил бүрийн 6 дугаар сарын байдлаар



1.4 Байгаль орчин

Цаг агаарын тойм, агаарын бохирдол

агаарын дундаж температур 12.0-18.0 градус дулаан буюу Өндөрширээт орчмоор дулаан, Мөнгөнморьтоор сэрүүвтэр

- өдөр ажиглагдсан агаарын хамгийн дулаан температур нь 25-34 градус буюу

Өндөрширээт, Борнуурт хамгийн их нь 34 градус, нутгийн зүүн хэсгээр сэрүүвтэр, үүнээс Эрдэнэ орчмоор 25 градус дулаан байв.

- шөнийн хугацаанд ажиглагдсан хамгийн бага температур нь -3.0-+4.0 градус буюу Өндөрширээт, Заамар орчмоор 4 градус дулаан, нутгийн зүүн хойд хэсгээр хасах градус руу орсон, Хамгийн хүйтэн нь Мөнгөнморьт болон Эрдэнэд -4 градус хүйтэн байв.

- бүх нутгаар сарын нийлбэр хур тунадас 26.6-117,2 мм, нутгийн баруун өмнөд хэсгээр буюу Аргалантад 26,6 мм хамгийн бага нь, харин хамгийн их нь Жаргалантад 117,2 мм, Угтаалд 90,1 мм тунадас оржээ.

- салхины их хурд 7-12 м/с, зарим газраар түр зуур 16-18 м/с хүрч, нөөлөг салхи ажиглагдлаа.

2014 оны 6 дугаар сарын цаг агаарын урьдчилсан төлөв.

Төв аймгийн нутгаар. Агаарын температурын сарын дундаж нь 17-22 градус дулаан буюу, ихэнх нутгаар олон жилийн дунджийн орчим байх төлөвтэй.

Сэрүүсэх хугацаа: Нэгдүгээр арав хоногийн сүүлч, хоёрдугаар арав хоногийн дунд болон сүүлч, гуравдугаар арав хоногийн эхэн ба сүүлчээр сэрүүсч уулархаг нутгаар шөнөдөө 3-8, өдөртөө 14-19 градус дулаан, голын сав газраар шөнөдөө 12-17, өдөртөө 22-27 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 9-14, өдөртөө 19-24 градус дулаан.

Харьцангуй дулаарах үе: Нэгдүгээр арав хоногийн эхэн, гуравдугаар арав

хоногийн дунд үеэр Туул голын сав нутгаар 29-34 градус хүрч халах төлөвтэй.

Бусад хугацаанд: Уулархаг нутгаар шөнөдөө 8-13, өдөртөө 20-25 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 13-18, өдөртөө 25-30 градус дулаан.

Энэ сард орох тунадасны нийлбэр хэмжээ нь олон жилийн дунджийн орчим бороо орох төлөвтэй.

Нэгдүгээр арав хоногийн сүүлч, хоёрдугаар арав хоногийн дунд болон сүүлч, гуравдугаар арав хоногийн эхэн ба сүүлчээр ихэнх нутгаар бороо орох төлөвтэй. Мөн нэгдүгээр арав хоногийн эхээр нутгийн баруун хэсгээр, хоёрдугаар арав хоногийн эхэн, гуравдугаар арав хоногийн дунд үеэр зарим газраар түр зуурын бороо орно. Дуу цахилгаантай. Борооны өмнө зарим газраар салхи түр зуур хүчтэй ширүүсч болзошгүй.




1.5 Гэмт хэрэг

Цагдаагийн байгууллагын мэдээгээр 2014 оны эхний 6 сард аймгийн хэмжээнд 530 гэмт хэрэг бүртгэгдэж 384 хүн холбогдож төр, иргэдийн өмчид 1379.4 сая ₮-ийн хохирол учирлаа.

Зураг 1.6

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн 6 дугаар сарын байдлаар



Зураг 1.7

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо, жил бүрийн 6 дугаар байдлаар



Гарсан гэмт хэргийн 39.8 хувь нь хулгай, 26.19 хувь нь иргэний эрүүл мэнд эрх чөлөөний -ний хэрэг, 11.31 хувь нь бусад хэрэг. 16.6 хувь нь замын осол, 4.7 хувь нь танхай дээрэм, 1.19 хувь нь хүний амийн хэрэг тус бүр эзлэв. Сэргэлэн, Баяндэлгэр, Баянжаргалан, Лүн, Эрдэнэ, сумдад 10000 хүнд 247-97 гэмт хэрэг ногдсон нь аймгийн дунджаас (60)-аас харьцангуй их байна.

Гэмт хэргийн тоо 2013 оны мөн үеэс 80 хэргээр өслөө.

Зуунмод суманд 27, эмэгтэй 630 эрэгтэй нийт 657 хүн эрүүлжүүлэгдсэн нь 2013 оны мөн үеэс 15 хүнээр буурлаа.

Зураг I.8

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ, жил бүрийн 6 дугаар сарын байдлаар, сая төгрөгөөр




Гэмт хэргийн тоо 2013 оны мөн үеэс 80 хэргээр өслөө.

Зуунмод суманд 27, эмэгтэй 630 эрэгтэй нийт 657 хүн эрүүлжүүлэгдсэн нь 2013 оны мөн үеэс 15 хүнээр буурлаа.



Шүүхийн шийдвэр гүйцэтгэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны 2014 оны эхний 6 сарын мэдээгээр ажиллагаа хийгдэж байгаа 1206 гүйцэтгэх хуудсанд нийт 3360.1 сая₮-ийн төлбөр тэтгэлэг ногдов. Үүнээс 488 гүйцэтгэх хуудсанд ногдох 603.5 сая₮-ийн материалд шүүхийн байцаан шийтгэх ажиллагаа хийгдэж, биелүүлбэл зохих 718 гүйцэтгэх хуудасны 2756.6 сая₮-өөс 322 хуудасны 1280.4 сая ₮-ийг биелүүлж, бодит биелэлтийн хувь гүйцэтгэх хуудсны тоогоор 44.85 хувь, үнийн дүнгээр 46.45 хувь болж 2013 оны мөн үеэс гүйцэтгэх хуудасны биелэлт 11.59 нэгжээр, үнийн дүнгийн биелэлт 19.08 нэгжээр тус тус өслөө.



II. Эдийн засгийн үзүүлэлт



II.1 Мөнгө, зээл, хадгаламж

ХААН, Хадгаламж, Хас банкны салбаруудын дүнгээр 2014 оны эхний 6 сард кассын орлого 352.0 тэрбум ₮, кассын зарлага 351.0 тэрбум ₮ болж, гүйлгээнд 2.1 тэрбум ₮ байна.

ХААН, Хадгаламж, Хас банкны салбарууд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад жижиг худалдаа, үйлдвэрлэлийг дэмжих үүднээс бичил бизнес болон нийт олгосон зээлийн үлдэгдэл 6 сарын 30-ний байдлаар 111.3 тэрбум ₮, байгаа нь өмнөх оны эцсээс 20.3 тэрбум ₮-өөр өслөө.

2014 он гарсаар Засгийн газраас бичил бизнесийг дэмжих ажлын хүрээнд зээлдэгч нарт 67.7 тэрбум төгрөгийн зээл олгожээ.

Иргэдийн хувийн хадгаламжинд 6 сарын 30-ний байдлаар 38.1 тэрбум ₮ байна. Харилцах дансны үлдэгдэл 6 сарын 30-ны байдлаар 285791 иргэний 12.6 тэрбум ₮ боллоо.



II.2 Төсөв, мөнгө

Орон нутгийн төсвийн орлого 24698.3 сая ₮ болж, төлөвлөгөө 91.07 хувиар

биелэгдэж. Суманд төвлөрүүлэх төсвийн орлого 915.3 сая ₮ болж, төлөвлөгөө 249.52 хувь биелж, Алтанбулаг сум 5.08 хувиар тасалдууллаа.

Аймагт төвлөрүүлэх төсвийн орлогын төлөвлөгөө 4993.3 сая ₮ болж 137.67 хувь биелж, Баянжаргалан, Жаргалант, Борнуур, Алтанбулаг, Цээл, Сүмбэр, Мөнгөнморьт, Өндөрширээт, Баянхангай, Батсүмбэр сумд 29.39-0.08 хувиар тасалдууллаа.




II.3 Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

2014 оны 6 дугаар сард ХҮИ /хэрэглээний үнийн индекс/ суурь үе болох 2010 оны 12 дугаар сараас 46,0%, өмнөх оны мөн үеэс 14,12%-аар тус тус өсч, өмнөх сараас 0,17 хувиар буурав. 6 дугаар сард өмнөх сартай харьцуулахад нийт өрхийн хүнсний хэрэглээнд өндөр хувийн жин эзэлдэг хүнсний ногооны дэд бүлэг 5,54%; талх гурил, будааны дэд бүлгийн үнэ 2,92%; жимс жимсгэний дэд бүлгийн үнэ 2,71%; төрөл бүрийн өөх, тосны дэд бүлгийн үнэ 0,72%; согтууруулах бус ундаа 2,19%-аар тус тус өсч, сүү сүүн бүтээгдэхүүн, өндөгний дэд бүлгийн үнэ 12,38%; мах махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 4,84%; саахар жимсний чанамал, зөгийн бал, чихэр, шоколадны дэд бүлгийн үнэ 3,36%; хүнсний бусад бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 0,79% -аар тус тус буурав.

Зураг II.1

Хэрэглээний үнийн аймгийн индекс (өмнөх оны 12 сар=100)



Хэрэглээний үнийн индексийн 2014 оны 6 дугаар сарын 0.17 хувийн бууралтын 0,25 нэгж (142,83%) нь хүнсний барааны бүлгийн үнийн бууралтаас; 0,09 нэгж (53,42%) нь холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлгийн үнийн бууралтаас голчлон шалтгаалсан байна.

Зураг II. 2

Инфляцийн өсөлтөд үзүүлсэн бүлгүүдийн нөлөөлөл

Бараа, үйлчилгээний бүлэг	2014 оны 6-р сард	
	пунктээр	хувиар
Бүгд	-0.17	100.00
01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	-0.25	142.83%
02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС	0.01	-3.60%
03. ХУВЦАС, БЭС БАРАА, ГУТАЛ	0.05	-27.11%
04. ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	0.06	-33.53%
05. ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	0.02	-10.76%
06. ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
07. ТЭЭВЭР	0.00	0.00%
08. ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	-0.09	53.42%
09. АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	-0.85%
10. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
11. ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
12. БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0.04	-20.41%



II. Тариалалт

7 сарын 1-ний байдлаар аймгийн дүнгээр 66082.0 гектар үр тариа, 4576.7 гектар төмс, 951.9 гектар хүнсний ногоо, 13987 гектар техникийн ургамал, 4150.2 гектар тэжээлийн ургамал, тариалсан нь 2013 оны мөн үеэс үр тариа 3922.5 гектар, тэжээлийн ургамал 413.2 гектар хүнсний ногоо 54.7 гектараар тус бүр өсч, техникийн ургамал 4734.0, төмс 531.9 гектараар тус бүр буурлаа.

Төл бойжилт

7 сарын 1-ний байдлаар оны эхний төллөх насны хээлтэгчийн 88.87 хувь 1423.87 мянган хээлтэгч мал төллөж, 1434.98 мянган төл гарсны 99.0 хувь 1420.70 мянган төл бойжиж байгаа нь урьд оны мөн үеэс төллөсөн хээлтэгч 10.8 хувь буюу 155.0 мянгаар; бойжиж буй төл 12.1 хувь 172.9 мянгаар тус бүр өслөө.



Гарсан төлийн 1.0 хувь болох 14277 толгой төл хорогдсон нь урьд оны мөн үеэс 80.8 хувь буюу 14277 төлөөр буурлаа. Гарсан ботгоны 0.8, унаганы 1.3, тугалын 1.3, хурганы 0.7, ишигний 1.3 хувь нь тус бүр хорогдов. Батсүмбэр, Эрдэнэсант, Сүмбэр, Баянчандмань, Баянцогт сумд гарсан төлийнхөө 3.61-2.64 хувь буюу 4236-361 төл хорогдуулсан нь аймгийн бүх төлийн хорогдлын 49.8 хувийг (бүгд 7112 төл) эзлэв.

Бойжуулсан төлийн тоо, төрлөөр, аймгийн дүнгээр

	2010	2011	2012	2013	2014
Бүгд	715.9	1120.1	1159.8	1247.8	1420.7
Тэмээ	0.3	0.4	0.5	0.5	0.5
Адуу	27.6	44.4	49.9	55.3	68.8
Үхэр	37.8	51.0	58.1	64.0	77.2
Хонь	396.2	600.7	615.0	677.7	763.8
Ямаа	254.1	423.5	436.3	450.3	510.4

Том малын зүй бус хорогдол


2014 оны 7 сарын 1-ний байдлаар оны эхний малын 0.4 хувь буюу 13860 том

мал зүй бусаар хорогдсон нь 2013 оны мөн үеэс 1.2 дахин буюу 17097 толгойгоор буурлаа. Хамгийн их хорогдолтой 5 сум Баянчандмань, Батсүмбэр, Сүмбэр, Мөнгөнморьт, Цээл сумд оны эхний малынхаа 1.7-0.8 хувь буюу 968-469 том мал зүй бусаар хорогдуулсан нь аймгийн бүх хорогдлын 26.28 хувь (бүгд 3643) эзлэв.

Зүй бусаар хорогдсон том малын тоо эхний хагас жилд төрлөөр, аймгийн дүнгээр /толгой/

	2010	2011	2012	2013	2014
Бүгд	507219	27252	13714	30957	13860
Тэмээ	67	3	5	23	12
Адуу	24426	1516	1060	1683	1188
Үхэр	24624	1373	1318	1939	1309
Хонь	221981	9492	5685	13096	6019
Ямаа	236121	14868	5646	14216	5332

Оны эхний тэмээний 0.4; адууны 0.4; үхрийн 0.5; хонины 0.3; ямааны 0.4 хувь нь тус бүр хорогдов. Бүх зүй бусаар хорогдсон малын 36.02 хувь нь өвчнөөр, 25.68 хувь нь хээлтэгч мал эзлэв.



II.5 Аж үйлдвэр

2014 оны эхний 6 сард (2005 оны зэрэгцүүлсэн үнэнд шилжүүлснээр) 4.89 тэрбум₮-ийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2013 оны мөн үеэс 62.2 хувь буюу 1.88 тэрбум ₮-өөр өслөө. Оны үнээр нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэнд эзлэх сумдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хувийн жингээс үзэхэд Зуунмод, Баянцагаан, Баянцогт, Баянчандмань, Жаргалант, Алтанбулаг, Эрдэнэ, Батсүмбэр, Борнуур, Өндөрширээт, Баян сумд 32.3-0.9 (эдгээр сумдын үйлдвэрлэлт 93.2) хувийг эзлэв.


Зураг II.6 Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, жил бүрийн 6 дугаар сарын байдлаар, мянган төгрөгөөр

АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛТ салбараар, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, млн.₮
GROSS INDUSTRIAL OUTPUT, by division, at constant prices of 2005 / mln tog

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР INDUSTRIAL SECTOR	2013 ҮЙ	2014 ҮЙ	2013 I-ҮЙ	2014 I-ҮЙ	Дүнээс хэсэг % Percentage share to total		2014% 2013%
					2013-I-ҮЙ	2014-I-ҮЙ	
Нийт дүн	760.02	1,011.89	3,015.04	4,891.88	100.0	100.0	162.2%
Ашигт малтмал олборлолт mining and quarrying	202.72	479.25	472.80	1,351.79	15.68%	27.63	285.9%
Боловсруулах аж үйлдвэр / manufacturing/	556.29	531.80	1,271.69	2,551.75	42.18	52.16	200.7%
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл Electricity, thermal energy, steam	1.01	0.83	1,270.55	986.34	42.1	20.20	77.8%


Аймгийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл өссөн нь ашигт малтмал олборлолт, архи, ундаа үйлдвэрлэл, сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, нэхмэлийн үйлдвэрлэл, арьс шир боловсруулах, үслэг арьс боловсруулалт, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл, мод, модон эдлэлийн үйлдвэрлэл, төмрийн үйлдвэрлэл өмнөх оноос 21 дахинаас-51.2 хувь буюу 879.0-21.8 сая₮-өөр өссөн нь нөлөөлөв.

Зураг II.5 Боловсруулах аж үйлдвэрийн зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, жил бүрийн 6 дугаар сарын байдлаар, мянган төгрөгөөр



Оны эхний 6 сарын нийт үйлдвэрлэлтэнд дулааны эрчим хүч 20.20, боловсруулах үйлдвэрлэл 52.16, уул уурхайн үйлдвэрлэл 27.64 хувийг тус тус эзлэв.

Зураг II.6 Аж үйлдвэрийн салбарын борлуулалтын бүтэц, дэд салбараар, жил бүрийн 6 дугаар сарын байдлаар, хувиар



II.6 Барилга


Төв аймгийн барилгын гүйцэтгэгч аж ахуйн нэгж байгууллага болон иргэд 2014 оны эхний хагас жилд 2333,8 сая₮-ийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэлээ. Гүйцэтгэлийг 2013 оны мөн үетэй харьцуулахад 58,66 хувь буюу 862,9 сая ₮-өөр өсөв. Барилга угсралт их засварын ажлын 25,32 хувь нь орон сууцны барилгад; 45,35 хувь нь орон сууцны бус барилгад; 29,32 хувь нь инженерийн барилга байгууламжид ногдож байна. Энэ нь 2013 эхний хагас жилтэй харьцуулахад орон сууцны барилгын ажил 21,11 пунктээр; орон сууцны бус барилгын ажил 3,39 пунктээр тус

тус өсч, инженерийн барилга байгууламжийн ажил 24,50 пунктээр буурсан үзүүлэлт юм.

Барилгын салбарт ажиллагсадын тоо 2013 оны мөн үеэс 106 хүнээр буурч, цалингийн сан 121,2 сая ₮-өөр өсөв.

Зураг II.7

Барилгынажлынгүйцэтгэл, жил бүрийн 6 дугаар сарын байдлаар, сая төгрөгөөр




II.7 Холбоо

Холбоо ашиглалтын орлого оны эхний 6 сард 140.4 сая ₮ болж, үүнээс хүн амаас орсон орлого 61.8 сая ₮ болж, өмнөх оны мөн үетэй харьцуулхад 1.8 дахин буюу 32.5 сая ₮-өөр өслөө.

Шуудан холбооны албаны үйлчилгээний орлого 48.8 сая ₮ болж, нийт орлогын 80.1 хувь нь хүн амд үйлчилсэний орлого байна. Нийт орлогын 19.79 хувийг албан бичгийн, 12.87 хувийг зорчигчдийн, 67.33 хувийг бусад орлого эзлэв.

Зураг II.10

Холбоо ашиглалтын орлого, жил бүрийн 6 дугаар сарын байдлаар, мянган төгрөгөөр



Аудит

Аймгийн аудитын газар 2014 оны эхний 6 сард 214 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийснээс 201 нь зөрчилгүй, 15 нь хязгаарлалттай, 5 нь санал дүгнэлт өгөхөөс татгалзсан дүгнэлтүүдтэй гарлаа. 72.4 сая₮-ийг аудитын үйлчилгээний төлбөрөөр улс, орон нутгийн төсөвт орууллаа.

Тайлангийн хугацаанд 1960.0 сая₮-ийн 39 төлбөрийн акт, албан шаардлагыг тавьж 720.7 сая₮-ийн 14-г барагдуулсан нь биелэлтийн хувь тоогоор 35.9, үнийн дүнгээр 36.7 хувьтай гарлаа.

Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл.

Аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2014 оны эхний 6 сард нийт 3074 иргэд, аж ахуйн нэгжийн үл хөдлөх хөрөнгөд баталгаажуулалтыг хийж 22.3 сая₮-ийн орлого орууллаа. Нийт орлогын 33.0 хувийг газар өмчлөлийн үйлчилгээнээс, 39.9 хувийг зээлийн барьцаанаас, 6.5 хувийг хувийн орон сууц, хашаа, байшингаас, 4.2 хувийг худалдааны үйлчилгээнээс, 4.2 хувийг бэлэглэлээс тус бүр оруулжээ.

Мал эмнэлэг

Мал эмнэлгийн бүх төрлийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 2014 оны эхний 6 сард 3595.1 мянган толгой мал хамрагдсан нь 2013 оны мөн үеэс 11.8 дахин буюу 3291.1 мянган толгойгоор нэмэгдлээ.

Урьдчилан сэргийлэх арга хэмжээ халдварт өвчнийнх 87.06 хувь, ариутгал халдваргүйтэлийнх 102.4 хувийн гүйцэтгэлтэй биелэгдлээ.